



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Уламжлалт Анагаах Ухааны Төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ДОА-2020/97/СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7000-3775
Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НЭМ	Нийгмийн эрүүл мэндийн төв



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12



1. Аудитын гэрчилгээ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 249
танай _____-ны № _____-т

УЛАМЖЛАЛТ АНАГААХ
УХААНЫ ТӨВИЙН ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухааны төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Уламжлалт анагаах ухааны Төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уламжлалт анагаах ухааны төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520288



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Б.Батцэцэгт Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-наас 2020 оны 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 ны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Соёлтой байгууллагын хөгжлийг хангаж, ээлтэй, чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Уламжлалт анагаах ухааны төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагч байгууллага байж, мэдлэгт суурилсан хүний нөөцийн чадамжийг дээшлүүлэх
- Тусламж үйлчилгээний чанар сайжруулах, аюулгүй байдлыг хангах
- Эдийн засгийн чадамж, ажлын үр дүнг дээшлүүлэх
- Монгол уламжлалт эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, НЭМ-ийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Уламжлалт анагаах ухааны төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Уламжлалт анагаах ухааны төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Accolus программ хангамж ашигладаг байна.

Уламжлалт анагаах ухааны төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Уламжлалт анагаах ухааны төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 29 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 37,837.2 мянган төгрөгөөс тооцон 7,569.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 7,569.5 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Уламжлалт анагаах ухааны төв нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,698.1 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	0	9.6	9.6
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	47,984.10	62,570.10	14,586.0
Үндсэн хөрөнгө	613,573.60	615,503.60	1,930.0
Хуримтлагдсан элэгдэл	(65945.30)	(88169.10)	(22,223.8)
Нийт хөрөнгө	595,612.40	589,914.20	(5,698.2)
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	595,612.40	589,914.20	(5,698.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	595,612.40	589,914.20	(5,698.2)

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тусгай зориулалтын материал болон эм боох материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын материалын 9,424.3 мянга, эм, оох материалын 3,844.6 мянга, бичиг хэргийн 286.1 мянга, түлш тослох материалын 549,9 мянга, 481,0 мянган төгрөгийн хүнсний материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,930.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр тавилга, эд хогшил худалдан авснаас шалтгаалжээ.

Эргэлтийн хөрөнгө 11,499.1 мянган төрөгийн хөрөнгийг актлаж данснаас хассан байна.

Хөрөнгө оруулалт, хандив, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байхгүй болно.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 589,914.2 мянган төгрөг болж 5,698.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хуримтлагдсан элэгдлийн дүнгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 372,199.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 372,094.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 254,848.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 112,320.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 5,031.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 372,094.4 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь төсвийг зориулалтын дагуу зүй зохистой зарцуулсан байна.

Нэмэлт төсөв: Эрүүл мэндийн яамнаас 1-10 сарын үндсэн үйл ажиллагаанаас давсан орлогыг зарцуулах эрх олгосны дагуу 210.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: бичиг хэргийн зардалд 210.6 мянга төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 29 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 29 эрсдэл тодорхойлж нийт 29 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 41,029.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 35,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 5529,4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Үүнд:

Тайлант хугацаанд 92,507.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан боловч эдгээрээс 57,086.0 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ нь Е-баримттай байна. 35,421.0 төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахаар асуудал байхгүй болно.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Уламжлалт анагаах ухааны төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 91 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож 93,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Уламжлалт анагаах ухааны төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Уламжлалт анагаах ухааны төв нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал
 - 1.1. Илрүүлэлт: Ор хоногийн мөнгийг харилцах дансанд журмын дагуу тушаадаггүй
 - 1.2. Эрсдэл: Хөрөнгө алдагдах, шамшигдах эрсдэлтэй.
 - 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах.
 - 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудиторын өгсөн зөвлөмжийн дагуу ор хоногийн төлбөрийг холбогдох журамд нийцүүлэн тухай бүр тушаах болно.
2. Дотоод хяналттай холбоотой асуудал
 - 2.1 Илрүүлэлт: Тээвэр шатахууны зарцуулалтыг норм нормативаар тооцож үзэхэд нормоос 159,1 мянган төгрөгөөр илүү шатахуун зарцуулсан баайна.
 - 2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.
 - 2.3 Өгсөн зөвлөмж: Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал 2019 оны дугаар 390 "жишиг норм батлах тухай" тушаалыг дагаж мөрдөх.
 - 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тус байгууллага нь авто машингүй бөгөөд үйл ажиллагаандаа дуудлагын авто машин хэрэглэдэг бөгөөд тээвэр шатахууны зарцуулсан шатахуун нь хууль журмыг зөрчин норм нормативыг илүү зарцуулсан зөрчил илэрсэн тул цаашид автомашинд зарцуулах шатахууны тооцоог норм нормативын дагуу зарцуулж ажиллах болно.



Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

СТ-1А

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

2019 оны 12 сарын 31-ний өдөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,984,075.09	62,579,726.06
33	АВЛАГА	00.00	9,600.00
335	Бусад авлага	00.00	9,600.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	47,984,075.09	62,570,126.06
351	Түүхий эд материал	46,126,125.09	59,395,126.06
35110	Тусгай зориулалттай материал	42,488,866.00	51,913,193.00
35130	Эм боох материал	3,637,259.09	7,481,933.06
354	Хангамжийн материал	1,857,950.00	3,175,000.00
35410	Бичиг хэргийн материал	1,262,830.00	1,549,000.00
35440	Түлц, шатах тослох материал	120.00	550,000.00
35460	Хүнсний материал	595,000.00	1,076,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	547,628,285.49	527,334,505.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	547,628,285.49	527,334,505.62
392	Биет хөрөнгө	547,422,035.53	527,197,005.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	506,188,188.00	506,188,188.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,872,939.60	-25,309,409.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,293,041.65	82,293,041.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,407,883.98	-49,402,410.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,598,400.00	25,528,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,562,645.79	-12,212,178.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	938,000.00	938,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-752,124.75	-826,624.71
393	Биет бус хөрөнгө	206,249.96	137,499.92
39301	Програм хангамж	556,000.00	556,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-349,750.04	-418,500.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	595,612,360.58	589,914,231.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	595,612,360.58	589,914,231.68
51	Засгийн газрын хувь оролцоо	595,612,360.58	589,914,231.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	408,972,992.00	408,972,992.00
51101	Өмч: - төрийн	408,972,992.00	408,972,992.00
512	Хуримтлагдсан үр дүн	185,873,681.08	180,175,552.18
51210	Өмнөх үеийн үр дүн	185,873,681.08	185,873,681.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-5,698,128.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	765,687.50	765,687.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	595,612,360.58	589,914,231.68

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

2019 оны 12 сарын 31-ний өдөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	304,179,600.00	372,679,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,668,300.00	5,370,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,668,300.00	5,370,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,668,300.00	5,370,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,668,300.00	5,370,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	299,511,300.00	367,308,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,191,300.00	254,848,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187,191,300.00	254,848,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	210,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	210,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	312,177,851.60	378,377,228.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,177,851.60	378,377,228.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,100,179.60	377,643,163.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,999,281.00	231,106,676.38
210101	Үндсэн цалин	112,106,400.00	163,429,999.65
210102	Нэмэгдэл	41,537,181.00	40,074,246.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,794,000.00	10,836,430.00
210104	Урамшуулал	14,561,700.00	16,766,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,844,200.00	33,621,824.87
210201	Тэтгэврийн даатгал	14,562,800.00	25,663,818.09
210202	Тэтгэмжийн даатгал	1,820,300.00	1,833,615.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,456,300.00	1,502,433.78
210204	Ажилгүйдлийн даатгал	364,100.00	278,585.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,640,700.00	4,343,371.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,141,783.00	14,863,132.00
210301	Гэрэл, цахилгаан	2,636,850.00	4,686,562.00
210302	Түлш, халаалт	6,030,078.00	6,760,980.00
210303	Цэвэр, бохир ус	5,474,855.00	3,415,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,779,221.50	22,030,415.34
210401	Бичиг хэрэг	3,253,970.00	3,793,280.00

210402	Тээвэр, шатахуун	00.00	1,150,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	632,227.50	838,393.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,216,160.00	3,173,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	676,864.00	1,322,630.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	11,752,371.69
2105	Нормативт зардал	47,826,523.09	41,513,833.34
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,027,368.09	17,620,228.34
210502	Хоол, хүнс	22,789,423.00	22,376,485.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,009,732.00	1,517,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,200,144.00	7,496,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	812,000.00	397,000.00
210604	Урсгал засвар	8,388,144.00	7,099,310.00
2107	Томилолт, зочны зардал	1,167,500.00	1,579,800.00
210702	Дотоод албан томилолт	1,167,500.00	1,579,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	842,672.00	3,207,392.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	738,560.00	2,751,280.00
210807	Газрын төлбөр	104,112.00	156,112.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,298,855.01	22,223,779.87
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,298,855.01	22,223,779.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,077,672.00	734,065.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	360,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-7,998,251.60	-5,698,128.90
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-7,998,251.60	-5,698,128.90

4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

2019 оны 12 сарын 31-ний өдөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	304,179,600.00	372,679,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,668,300.00	5,370,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,668,300.00	5,370,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,668,300.00	5,370,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,668,300.00	5,370,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	299,511,300.00	367,308,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,191,300.00	254,848,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187,191,300.00	254,848,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	210,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	210,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	304,179,600.00	370,749,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,179,600.00	370,749,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,101,928.00	370,015,034.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,999,281.00	235,612,201.25
210101	Үндсэн цалин	112,106,400.00	167,560,401.52
210102	Нэмэгдэл	41,537,181.00	39,911,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,794,000.00	11,377,099.73
210104	Урамшуулал	14,561,700.00	16,763,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,844,200.00	29,123,400.00
210201	Тэтгэврийн даатгал	14,562,800.00	19,803,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,820,300.00	2,329,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,456,300.00	1,863,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,100.00	466,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,640,700.00	4,659,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,141,783.00	14,863,132.00
210301	Гэрэл, цахилгаан	2,636,850.00	4,686,562.00
210302	Түлш, халаалт	6,030,078.00	6,760,980.00
210303	Цэвэр, бохир ус	5,474,855.00	3,415,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,463,609.50	10,741,263.65
210401	Бичиг хэрэг	3,201,230.00	4,106,950.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,700,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	632,227.50	777,046.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,617,240.00	2,713,820.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,012,912.00	1,382,100.00
2105	Нормативт зардал	46,593,986.50	52,593,066.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,638,792.50	23,523,161.00
210502	Хоол, хүнс	22,281,543.00	23,009,015.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,673,651.00	6,060,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,304,896.00	22,127,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,371,290.00	984,990.00
210602	Тавилга	00.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	5,933,606.00	18,142,290.00
2107	Томилолт, зочны зардал	1,167,500.00	1,579,800.00
210702	Дотоод албан томилолт	1,167,500.00	1,579,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,586,672.00	3,374,892.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,482,560.00	2,980,127.00
210807	Газрын төлбөр	104,112.00	156,112.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	60,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,077,672.00	734,065.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	360,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,930,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,930,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,930,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,930,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,930,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,930,000.00



4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

2019 оны 12 сарын 31-ний өдөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	193,370,086.91	603,108,766.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	193,370,086.91	603,108,766.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	17,947,747.38	17,947,747.38
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,698,128.90	-5,698,128.90
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	180,175,552.18	589,914,231.68

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2019 оны 12 сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00	00	00	00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	304,542,300.0	304,179,600.0	372,199,400.0	372,094,434.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,542,300.0	304,179,600.0	372,199,400.0	372,094,434.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,542,300.0	298,101,928.0	371,839,400.0	371,734,434.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,034,600.0	181,999,281.0	235,686,800.0	235,612,201.3
210101	Үндсэн цалин	112,106,400.0	112,106,400.0	167,635,000.0	167,560,401.5
210102	Нэмэгдэл	41,572,500.0	41,537,181.0	39,911,200.0	39,911,200.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,794,000.0	13,794,000.0	11,377,100.0	11,377,099.7
210104	Урамшуулал	14,561,700.0	14,561,700.0	16,763,500.0	16,763,500.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,844,200.0	21,844,200.0	29,123,400.0	29,123,400.0
210201	Тэтгэврийн даатгал	14,562,800.0	14,562,800.0	19,803,900.0	19,803,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,820,300.0	1,820,300.0	2,329,900.0	2,329,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,456,300.0	1,456,300.0	1,863,900.0	1,863,900.0
210204	Ажилгүйдлийн даатгал	364,100.0	364,100.0	466,000.0	466,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,640,700.0	3,640,700.0	4,659,700.0	4,659,700.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,863,900.0	14,141,783.0	14,863,900.0	14,863,132.0
210301	Гэрэл, цахилгаан	3,090,400.0	2,636,850.0	5,090,400.0	4,686,562.0
210302	Түлш, халаалт	15,577,500.0	6,030,078.0	5,277,500.0	6,760,980.0
210303	Цэвэр, бохир ус	1,196,000.0	5,474,855.0	4,496,000.0	3,415,590.0
2104	Хангамж, бараа материалын зардал	8,472,400.0	8,463,609.5	10,472,400.0	10,469,316.7
210401	Бичиг хэрэг	1,869,100.0	3,201,230.0	3,369,100.0	3,896,350.0
210402	Тээвэр, шатахуун	2,284,500.0	00.0	2,284,500.0	1,700,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,000.0	632,227.5	720,000.0	777,046.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,716,700.0	3,617,240.0	2,716,700.0	2,713,820.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	882,100.0	1,012,912.0	1,382,100.0	1,382,100.0
2105	Нормативт зардал	46,595,500.0	46,593,986.5	52,595,500.0	52,593,066.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,294,900.0	20,638,792.5	23,794,900.0	23,523,161.0
210502	Хоол, хүнс	22,736,000.0	22,281,543.0	22,736,000.0	23,009,015.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,564,600.0	3,673,651.0	6,064,600.0	6,060,890.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,313,200.0	18,304,896.0	24,063,200.0	24,057,280.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,522,000.0	12,371,290.0	2,772,000.0	1,674,990.0
210602	Тавилга	00.0	00.0	3,000,000.0	3,000,000.0
210604	Урсгал засвар	8,791,200.0	5,933,606.0	18,291,200.0	19,382,290.0
2107	Томилолт, зочны зардал	1,584,000.0	1,167,500.0	1,584,000.0	1,579,800.0
210702	Дотоод албан томилолт	1,584,000.0	1,167,500.0	1,584,000.0	1,579,800.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,834,500.0	5,586,672.0	3,450,200.0	3,436,239.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.0	00.0	250,000.0	240,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,484,000.0	5,482,560.0	2,984,000.0	2,980,127.0
210807	Газрын төлбөр	156,200.0	104,112.0	156,200.0	156,112.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.0	00.0	60,000.0	60,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.0	00.0	360,000.0	360,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.0	00.0	360,000.0	360,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.0	00.0	360,000.0	360,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	304,542,300.0	304,179,600.0	372,199,400.0	372,094,434.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,191,300.0	187,191,300.0	254,848,400.0	254,813,634.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	187,191,300.0	187,191,300.0	254,848,400.0	254,813,634.9
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	112,320,000.0	112,320,000.0	112,320,000.0	112,249,800.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,320,000.0	112,320,000.0	112,320,000.0	112,249,800.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,031,000.0	5,031,000.0	5,031,000.0	5,031,000.0
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,031,000.0	4,668,300.0	5,031,000.0	5,031,000.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.0	18.0	18.0	18.0
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	15	15
620003	Үйлчлэх ажилтан	2	2	2	2